



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 643

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн цэргийн 0288 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 35,031,568.07 (гучин таван сая гучин нэгэн мянга таван зуун жаран найман төгрөг долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Хилийн цэргийн 0288 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс сэлбэг, хоёрдогч түүхий эд, төмрийн хаягдлыг ялган тоолж бүртгэх, худалдах, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийн хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

137602770
28-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
64 дугаар тогтоолын хавсралт

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал-тад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлаг-дсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	DH-56 маркийн хэвлэх машин	4/1/2017	1.00	13,750,000.00	13,750,000.00	0.00
2	DH-47 маркийн хэвлэх машин	1/1/2012	1.00	18,500,000.00	18,500,000.00	0.00
3	Print Master STO-52 маркийн хэвлэх машин	1/25/2013	1.00	161,568.07	161,568.07	0.00
4	Огтлогооны машин	6/30/2004	1.00	2,620,000.00	2,620,000.00	0.00
Нийт дүн				35,031,568.07	35,031,568.07	0.00
				(гучин таван сая гучин нэгэн мянга таван зуун жаран найман төгрөг долоон мөнгө)		